



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өндөр-Улаан сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: АРА-2024/19-НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Архангай аймаг 2024 он	Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа Утас: 7033-3141 Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn Аудитын менежер Д.Нэргүйбаатар Утас: 7033-2860 Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn Ахлах аудитор Н.Алтантуяа Цахим хаяг: Altantuyan@audit.gov.mn
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.	ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	2
2.	АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	4
2.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	4
2.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	4
2.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	5
2.4	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	6
2.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	6
2.6	Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	7
<b>3.</b>	<b>АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....</b>	<b>8</b>
3.1	Төлбөрийн акт.....	8
3.2	Хариуцлага тооцуулах албан шаардлага.....	8
<b>3.3</b>	<b>Зөвлөмж.....</b>	<b>9</b>
<b>4.</b>	<b>АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....</b>	<b>10</b>

## 1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ӨНДӨР-УЛААН СУМЫН ЗАСАГ  
ДАРГА Ю.БААСАНЖАРГАЛ ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АРХАНГАЙ АЙМАГ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,  
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,  
Утас/Факс: (976) 7033 3141,  
Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn

2024.03.28 № 172  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасны дагуу Архангай аймгийн Өндөр -Улаан сумын засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Архангай аймгийн Өндөр -Улаан сумын засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитаар илэрсэн доорх алдаа зөрчил нь материаллаг боловч санхүүгийн тайланд үзүүлэх үр нөлөө нь өргөн тархаагүй тул Хязгаарлалттай дүгнэлт хүргүүлж байна. Үүнд:

1. Хоршоо хөгжүүлэх сангийн эхний үлдэгдлээс анхан шатны баримтгүй 19,845.0 мянган төгрөгийг хувь хүний дансанд шилжүүлсэн, төрийн сангийн дотоод зарлагын гүйлгээнд тавих хяналтыг хэрэгжүүлээгүй байна.
2. Хоршоо хөгжүүлэх сангийн 100,993.4 мянган төгрөгийн хугацаа хэтэрсэн зээлийг барагдуулах арга хэмжээ авч ажиллаагүй.

Дээрх зөрчлүүд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төсвийн тухай хууль болон Төрийн сангийн төлбөр тооцооны журам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын тушаалаар баталсан "Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам"-ыг зөрчсөн бөгөөд аудитын эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### Асуудлыг онцолсон хэсэг

МУЗГ-ын 2022 оны 2 дугаар тогтоолоор баталсан “Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ын дагуу тус орлогыг тайлант оноос захиран зарцуулж, тайлагнах болсон байна

#### **Бусад асуудлын хэсэг**

Сумын засаг дарга нь 2023 оны жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг 6 зорилтын хүрээнд 128 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг аймгийн Засаг даргын тамгын газрын хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсээс 87.1 хувьтай үнэлсэн байна.

*Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.*

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ мянган төгрөгөөр /

Код:	Тайлангийн үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	778,429.2	781,627.4
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	217,758.1	203,336.0
33	АВЛАГА	480,827.8	497,808.4
35	БАРАА МАТЕРИАЛ	79,843.3	63,108.0
36	НӨӨЦИЙН БАРАА	0.0	17,375.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,088,896.8	2,045,570.8
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,088,896.8	2,045,570.8
39200	Биет хөрөнгө	2,067,193.3	2,024,517.3
39300	Биет бус хөрөнгө	21,703.5	21,053.5
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,867,326.0	2,827,198.2
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,867,326.0	2,827,198.2
51	Засгийн газрын хувь оролцоо	2,867,326.0	2,827,198.2
51100	Засгийн газрын оруулсан капитал	496,878.3	496,878.3
51200	Хуримтлагдсан үр дүн	2,071,748.0	2,031,620.2
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	298,699.6	298,699.6
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,867,326.0	2,827,198.2

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ мянган төгрөгөөр /

Код:	Тайлангийн үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,108,162.0	2,133,383.1
11	ТАТВАРЫН ОРЛОГО	592,655.5	620,999.2
110	Орлогын албан татвар	314,358.7	359,602.4
1100	Хувь хүний орлогын албан татвар	314,358.7	359,453.9
1102	Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч	0.0	148.5
113	Хөрөнгийн албан татвар	138,960.8	155,561.0
118	Бусад татвар, төлбөр, хураамж	139,336.0	105,835.8
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	605,494.4	342,178.8
120	Нийтлэг татварын бус орлого	605,494.4	342,178.8
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,910,012.1	1,170,205.0
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,311,424.6	1,591,659.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,311,424.6	1,591,659.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,181,543.2	1,585,909.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	427,369.5	514,785.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	60,136.2	64,253.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	160,629.7	32,706.8
2104	Хангамж, бараа материалын зардал	54,383.7	88,311.8
2105	Нормативт зардал	405.0	1,720.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	26,139.7	14,817.0

**Архангай аймгийн Өндөр-Улаан сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан**

2107	Томилолт, зочны зардал	6,470.0	9,813.1
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	104,241.1	304,441.5
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	341,768.3	555,061.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,129,881.5	5,750.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	796,737.3	541,723.7
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	4,731,220.3	577,057.1
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-3,934,483.0	-35,333.4

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ мянган төгрөгөөр /

Код:	Тайлангийн үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	2,706,327.0	1,958,200.1
11	ТАТВАРЫН ОРЛОГО	592,655.5	620,999.2
110	Орлогын албан татвар	314,358.7	359,602.4
1100	Хувь хүний орлогын албан татвар	314,358.7	359,453.9
1102	Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч	0.0	148.5
113	Хөрөнгийн албан татвар	138,960.8	155,561.0
118	Бусад татвар, төлбөр, хураамж	139,336.0	105,835.8
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	35,236.4	47,990.3
1181	Газрын төлбөр	53,486.1	35,500.0
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	50,613.5	22,345.6
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	203,659.5	166,995.8
120	Нийтлэг татварын бус орлого	203,659.5	166,995.8
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,910,012.1	1,170,205.0
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,984,765.5	1,167,534.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,984,765.5	1,167,534.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	854,884.0	1,162,034.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	433,940.0	516,019.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	53,165.7	63,577.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	162,069.7	35,235.8
2104	Хангамж, бараа материалын зардал	39,550.8	65,393.3
2105	Нормативт зардал	0.0	1,500.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	17,884.0	13,540.0
2107	Томилолт, зочны зардал	6,470.0	8,499.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	82,203.9	335,381.5
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	59,600.0	122,887.6
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,129,881.5	5,500.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	721,561.5	790,665.9
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	571,519.1	655,242.9
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	571,519.1	655,242.9
2200	Дотоод эх үүсвэрээр	571,519.1	655,242.9
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-571,519.1	-655,242.9
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-240,000.0	-149,845.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	240,000.0	149,845.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-89,957.6	-14,422.0
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	307,715.6	217,758.1
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	217,758.1	203,336.0

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ мянган төгрөгөөр /

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	7,671,461.4	7,671,461.4
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-869,652.5	-869,652.5
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	6,801,808.9	6,801,808.9
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.0	0.0
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.0	0.0
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.0	0.0
7	Өмчид гарсан өөрчлөлт	0.0	0.0
8	Зарласан ногдол ашиг	0.0	0.0
9	Тайлант үеийн үр дүн	-3,934,483.0	-3,934,483.0
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,867,326.0	2,867,326.0
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	2,867,326.0	2,867,326.0
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-4,794.4	-4,794.4
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,862,531.6	2,862,531.6
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.0	0.0
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.0	0.0
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.0	0.0
17	Өмчид гарсан өөрчлөлт	0.0	0.0
18	Зарласан ногдол ашиг	0.0	0.0
19	Тайлант үеийн үр дүн	-35,333.4	-35,333.4
20	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,827,198.2	2,827,198.2

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ мянган төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,094,897.9	1,860,254.8	234,643.1	88.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,155,676.5	1,133,352.6	22,323.9	98.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,151,176.5	1,128,852.6	22,323.9	98.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	522,609.9	516,019.4	6,590.5	98.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	65,326.4	63,577.6	1,748.8	97.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	212,023.7	211,132.4	891.3	99.6
2104	Хангамж, бараа материалын зардал	63,623.5	63,623.5	-	100.0
2105	Нормативт зардал	1,500.0	1,500.0	-	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	93,328.0	93,327.8	0.2	100.0
2107	Томилолт, зочны зардал	8,710.3	8,499.0	211.3	97.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	100,125.0	87,246.5	12,878.5	87.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	83,929.7	83,926.5	3.3	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,500.0	4,500.0	-	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,500.0	4,500.0	-	100.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	691,521.4	577,057.1	114,464.3	83.4
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	247,700.0	149,845.0	97,855.0	60.5
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,094,897.9	1,838,734.0	256,163.9	87.8
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,645,245.6	1,700,160.0	(54,914.4)	103.3

**Архангай аймгийн Өндөр-Улаан сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан**

35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	449,652.3	138,574.0	311,078.3	30.8
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		57,893.9	(57,893.9)	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		36,373.2	(36,373.2)	
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	9	9		100.0
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	31	31		100.0
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	31	31		100.0

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ мянган төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	115,246.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	65,446.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	61,567.4
2104	Хангамж бараа материалын зардал	1,769.8
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	20,836.5
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	38,961.1
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,879.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,000.0
213	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,879.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	49,800.0
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	115,246.4
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	115,246.4

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 1 алдаа<sup>1</sup> илэрч, санхүүгийн тайланд залруулга хийлээ.

- Хоршоо хөгжүүлэх сангийн 19,845.0 мянган төгрөгийн авлагыг дутуу, мөнгөн хөрөнгийг 19,845.0 мянган төгрөгөөр илүү тайлагнасныг аудитын явцад залрууллаа. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 “үнэн зөв байх”, 14 дүгээр зүйлийн 14.4.2 “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлагыг нягтлан бодох бүртгэлд заавал бүртгэнэ” гэсэн заалт болон аудитын иж бүрэн байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна

Аудитаар залруулагдаагүй нийт 126,280.9 мянган төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрч, 19,845.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 2 албан тушаалтанд сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага, 106,435.9 мянган төгрөгийн 2 зөвлөмж хүргүүлжээ. Энэхүү илэрсэн зөрчил нь гүйцэтгэлийн үе шатанд тооцсон гүйцэтгэлийн материаллаг байдал 23,567.6 мянган төгрөгөөс дээгүүр байгаа тул Хязгаарлалттай дүгнэлт хүргүүлэв.

#### 3.1 Төлбөрийн акт

3.1.1 Тайлант онд Өндөр-Улаан сумын хоршоо хөгжүүлэх сангийн 100010555401 тоот данс / мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл/-аас төрийн сангийн дотоод гүйлгээгээр 2023.02.03-нд 14,245.0 мянган төгрөг, 2023.02.27-нд 5,600.0 мянган төгрөг нийт 19,845.0 мянган төгрөгийг сумын хувь хүний орлогын албан татварын 100010500911 тоот дансанд үндэслэх анхан шатны баримтгүйгээр гүйлгээ хийж, уг данснаас 2023.02.06-нд 14,245.0 мянган төгрөг, 2023.02.28-нд 5,600.0 мянган төгрөгийг санхүү албаны даргын 5141212328 тоот ХААН банкин дахь данс руу шилжүүлэн авсан зөрчил илэрлээ.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.5-т “Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна”, 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

*Шийдвэрлэсэн нь: Хоршоо хөгжүүлэх сангийн дансанд буцаан төлүүлэх төлбөрийн акт тогтоож, аудитын явцад төлбөрийг бүрэн барагдууллаа.*

#### 3.2 Хариуцлага тооцуулах албан шаардлага

3.2.1. Тус сумын Санхүү албаны дарга нь Засаг даргын гүйлгээ баталгаажуулах цахим гарын үсгийг ашиглан албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлж хоршоо хөгжүүлэх сангийн дансны эхний үлдэгдлээс 19,845.0 мянган төгрөгийг өөрийн хувийн дансанд шилжүүлэн авсан бөгөөд тус гүйлгээнд сумын Засаг даргын зүгээс тавих хяналтыг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 37.1.7 “Төсвийн орлого, зарлага, хөрөнгө, өр төлбөрийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу холбогдох дансанд бүртгэх, тайлагнах”, Сангийн Сайдын 2015 оны 24 дүгээр тушаалаар баталсан (2023 онд хүчин төгөлдөр мөрдөж байсан) “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 7.4-д “Төсвийн байгууллага нь Төрийн сангаас өгсөн нэр, нууц үгийг ашиглан Сангийн яамны цахим хуудаснаас онлайн хуулга, тайланг авч өөрийн нягтлан бодох бүртгэлийн мэдээлэлтэй тулган өдөр тутам хяналт тавьж ажиллана. Төрийн сангаас өгөгдсөн

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

**нэр, нууц үгийг бусад этгээдэд өгөх, ашиглуулахыг хориглоно”** гэж заасныг тус тус зөрчсөн байна.

*Шийдвэрлэсэн нь: Дээрх албан тушаалтнуудад сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлэх*

### **3.3 Зөвлөмж**

#### **3.3.1 Зээлийн авлагатай холбоотой асуудал**

**Илрүүлэлт:** Хоршоо хөгжүүлэх сангаас 2021 онд зээл авсан 92 иргэний 2023 онд төлөгдөх нийт 100,993.4 мянган төгрөгийн хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй байна.

Энэ нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын тушаалаар баталсан “Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын 3 дугаар зүйлийн 3.4.11-т “Сангаас олгосон зээлийн эргэн төлөлтийн төлбөрийг зээлдэгч төлөхгүй тохиолдолд сумын Засаг дарга уг төлбөрийг төлүүлэх арга хэмжээг авч зээлийн дансанд төвлөрүүлнэ”, 10 дугаар зүйлийн 10.1-т “Хяналтын зөвлөл нь зээлдэгчтэй байгуулсан зээлийн гэрээ, эргэн төлөлтийн хуваарийн дагуу зээлийн эргэн төлөлт зээлийн хүү, алдангийг тухай бүр төлүүлж буйд хяналт тавина.”, 11 зүйлийн 11.3-т “Энэ журмыг зөрчсөн гэм буруутай этгээд санд учирсан хохирлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцан барагдуулна” гэсэн заалтыг зөрчиж байна.

**Зөвлөмж:** *Хугацаа хэтэрсэн зээлийн авлагыг эргэн төлөлтийн хуваарийн дагуу төвлөрүүлэх талаар холбогдох арга хэмжээг авч ажиллах*

#### **3.3.2 Орлоготой холбоотой асуудал**

**Илрүүлэлт:** Тайлант оны орлогын төлөвлөгөө гүйцэтгэлийг хянаж үзэхэд газрын дуудлага худалдааны орлого 1,564.5 мянга, хог хаягдлын хураамж 3,878.0 мянга, нийт 5,442.5 мянган төгрөгөөр тасарсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.-т “Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэсэн заалтыг зөрчсөн байна

**Зөвлөмж:** *Орон нутгийн орлогын төлөвлөлтөд анхаарч, орлогыг нэр төрлөөр жигд ханган биелүүлэх талаар холбогдох арга хэмжээг авч ажиллах*

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ” гэсэн заалтын дагуу зөвлөмжийн мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2024 оны 04 дүгээр сарын 25-ны дотор ирүүлнэ үү.

**Зөвлөмж:** *Орлогын төлөвлөлтөд анхаарч, нийт дүнгээр орлогын төлөвлөгөөг биелүүлэн ажиллах арга хэмжээг авах*

Зөвлөмжийн биелэлтийг тооцож, холбогдох нотлох баримтын хамт 2024 оны 12 дугаар сарын 05-ны дотор Архангай аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

*Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.*

#### 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

##### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Зээл төлүүлэх холбогдох арга хэмжээг аваагүй	1	100993.4					1	100993.4				
Төлөвлөсөн 2 орлого тасарсан	1	5442.5					1	5442.5				
Анхан шатны баримтгүй гүйлгээ хийсэн	1	19845.0	1	19845.0								
Албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн	1	0							1	1		
Хяналт тавих үүргээ биелүүлээгүй	1	0							1	1		
	5	126280.9	1	19845.0			2	106435.9	2	2		

##### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай тогтоомжтой холбоотой зөрчил								
Шилэн дансанд мэдээллийг оруулаагүй	1	0	0	0	1	0	0	0
	1	0	0	0	1	0	0	0